МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
УЛСЫН БҮРТГЭЛИЙН
ЕРӨНХИЙ ГАЗАР
Цагдаагийн гудамж, 11 дүгээр хороо,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14171
Утас: 32 05 02, Цахим шуудан: contact@burtgel.gov.mn,
Цахим хуудас: www.burtgel.gov.mn
2024.05.30 № 1/7403
танай ________ -ны №________ -т

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН
САНХҮҮ- НИЙЦЛЭЛИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
Ц.НАРАНЧИМЭГ ТАНАА

Төрийн аудитын тухай тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь заалтыг хэрэгжүүлэн тус газрын төсвийн захирагчийн болон Төрийн өмчийн оролцоотой байгууллагын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээний төлөвлөгөөний болон илэрсэн зөрчлийн биелүүлсэн талаарх тайланг гарган үүгээр хүргүүлж байна.

Хавсралт 9 хуудастай.

ДАРГА Д.ДЭЛГЭРСАЙХАН

142410.46

Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2024 оны
1/2703 дугаар албан бичгийн 1 дүгээр хавсралт

1118266216 ГСТ6095

# УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН 2023 ОНЫ НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧЛИЙГ АРИЛГАСАН ТАЛААРХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ БОЛОН ТАЙЛАН /ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ УБЕГ/

2024 оны 05 сарын 30

| Д/д | Илэрсэн зөрчил болон хэрэгжүүлээгүй хуулийн заалт | Хэрэгжүүлэх үйл ажиллагаа | Биелэлт |
|---|---|---|---|
| | **Төлбөрийн акт** | | |
| 1. | "Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;"Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-т “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэж заасныг тус тус зөрчсөн байна. | Тайлант онд нэр бүхий 15 албан тушаалтанд 2,6 сая төгрөгийн илүү цагийн хөлсийн олгосныг буруутай албан хаагчаар төлүүлэн Улсын төсөвт төвлөрүүлэх | Илүү олгосон 15 албан хаагчийн 2.586,0 сая төгрөгийг 4 болон 5 сарууддад тэнцүү хэмжээгээр цалингаас суутган ажиллаж, суутган Үндэсний аудитын газрын 100900000601 тоот дансад төвлөрүүлсэн. Төлбөрийн даалгаврыг хавсаргав.<br><br>***Биелэлт 100 хувь*** |
| | **Албан шаардлага** | | |
| 1. | Төрийн үнэт цаас хэвлэл ТӨОХХК-аас худалдан авсан гадаад паспортын бэлдцээс 1.407.8 сая төгрөгийн үнэ бүхий 20.116 ширхэг алдаатай бэлдцийн үлдэгдлийг үйлдвэрээс шалтгаалсан эсвэл техникийн алдаа эсэхийг хянаж шийдвэрлээгүй байна. Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/08 дугаар тушаалаар Төрийн үнэт цаас хэвлэл ТӨОХХК-ийн нийлүүлсэн хэвлэх машины тохируулга хийхэд ашигласан үндэсний энгийн | Төрийн өмчийг зарцуулалтыг сайжруулах, хяналттай болгох | "Төрийн үнэт цаас хэвлэл" ТӨОХХК нь 4 хүний бүрэлдэхүүнтэй баг 2024 оны 1-р сарын 18-аас 24-ний өдрүүдэд нийт 20.116 ширхэг бэлдцийн тоо болон чанарын шалгалтыг хийн 2.112 ширхэг хэвлэлтгүй, 1.187 ширхэг нь чипэнд мэдээлэл оруулах зорилгоор, бэлдэц, бэлдцийн үйлдвэрлэлтийн явцад гарсан алдаанаас шалтгаалан зураг өөрчлөлт орсон тул дахин хэвлэгдсэн бэлдэц зэргийг тооцож үйлдвэрийн алдаатай буюу нийт 3.299 ширхэг бэлдэцийг хүлээн зөвшөөрсөн, харин үлдсэн 16.811 ширхэгийг гадаад паспортын хүчингүй болсон шалтгааныг судалж шинээр үйлдвэрлэл явуулахад систем турших, тоног төхөөрөмжийн тохиргоо, засвар үйлчилгээ хийх, ажилтнуудыг сургаж, |

| | | | |
|---|---|---|---|
| | гадаад паспортын бэлдцийг нягтлан шалгаж, техникийн дүгнэлт гаргах ажлын хэсгийг байгуулсан боловч дүгнэлт гаргаагүй байна. | | дадлагажуулах ажилд зориулагдсан гэж үзэн үйлдвэрлэлийн шаардлагаар зарцуулагдсан гэж дүгнэлт гаргасан болно. Ажлын хэсгийн дүгнэлтийг хавсаргав<br><br>***Биелэлт 100 хувь*** |
| 2. | "Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" болон Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1-т заалтыг зөрчсөн байна. | Төсвийн хөрөнгөөр 20,5 сая төгрөгийг спортын арга хэмжээнд зарцуулснаас 3,5 сая төгрөгийн шагналд, 7.0 сая төгрөгийн биеийн тамирын хувцас худалдан авахад, 10,1 сая төгрөгийн хоол, бусад зардалд зарцуулсныг цаашид гаргахгүй байх | Төсвийн тухай хууль болон Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн, цаашид уг зөрчлийг давтан гаргахгүй ажиллана.<br><br>***Биелэлт 100 хувь*** |
| 3. | "Төсвийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.3-т "Үндсэн үйл ажиллагааны зардлаас туслах үйл ажиллагаанд зориулж шууд болон шууд бусаар хөрөнгө зарцуулахыг хориглоно" гэж заасныг тус тус зөрчсөн байна. | Малчинд 7,5 сая төгрөгийн цалин, НДШ-д 0,9 сая төгрөгийг төлж, 8,4 сая төгрөгийн зардал гаргасныг залруулах, гэрээт үйлчилгээний албан хаагч болгох | Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2024 оны 04 сарын 02-ны Б/212 тоот тушаалаар малчин Б.Бум-Эрдэнийг ажлаас чөлөөлсөн. Тушаалын хуулбарыг хавсаргав.<br><br>***Биелэлт 100 хувь*** |
| **Зөвлөмж** | | | |
| 1. | Элэгдлээрээ үлдэх өртгөө бүрэн нөхсөн хөрөнгийг асуудлыг хууль журамд нийцүүлэн бүртгэлийг хийгээгүй байна. | Санхүүгийн тайланд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 421 нэр төрлийн 2.945,8 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг холбогдох журмын дагуу дээд газарт хүргүүлж, шийдвэрлүүлэх, | Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 421 нэр төрлийн 2.945,8 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг холбогдох журмын дагуу ХЗДХЯ-нд 2024 оны 05 сарын 13-ны өдрийн 1/6398 тоот албан бичгээр хүргүүлсэн. Шийдвэр гарахаар санхүүгийн тайланд тусгахаар ажиллаж байна. Албан тоотыг хавсаргав. |
| 2. | "Данс автоматжуулах үйлчилгээ үзүүлэх гэрээний 2.1-т "Энэхүү гэрээ нь 2017 оны 04 дүгээр сарын 11-ний өдрөөс 2018 оны 04 дүгээр сарын 04 дүгээр сарын 11-ний өдрийг хүртэл 1 | Арилжааны банкинд данс нээсэн зөвшөөрлийг хугацаа дууснаыг дээд газарт асуудлыг тавьж шийдвэр гаргуулах | Арилжааны банк болох Төрийн банкны байгуулсан гурвалсан гэрээг "Төсвийн орлогын 0 үлдэгдэлтэй дансны гэрээ"-г 2024 оны 06 сарын 29-ны өдөр дуусах хугацаатай боловч 2 талаас санал гараагүй тохиолдолд гэрээний заалтаар 1 жил дахин сунгагдахаар байгаа юм. Харин |

| | | | |
|---|---|---|---|
| | /нэг/ жилийн (хуанлийн) хугацаанд хүчин төгөлдөр байна.", Төсвийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.3-т "Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрлөөр банканд тусдаа данс нээснээс бусад тохиолдолд төсөвт хамаарах бүх гүйлгээг Төрийн сангийн нэгдсэн дансаар гүйцэтгэнэ", 35.4-т "Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бичгээр ирүүлсэн зөвшөөрөлгүйгээр банк аливаа төсвийн байгууллагад данс нээхийг хориглоно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна. | | гэрээний 5 дугаар зүйлийн 5.4 дэх заалтад өөрчлөлт оруулах саналаа албан тоотоор болон цахим шуудангаар хүргүүлсэн болно. |
| 3. | Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7-т "тогтоосон журмын дагуу анхан шатны бүртгэлийг хөтөлж, нягтлан бодох бүртгэлийн тайлан тэнцэл, статистикийн мэдээ гаргах ажлыг зохион байгуулж, тэдгээрийн үнэн зөвийг хариуцах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна. | Гадаад паспортыг анх болон давтан авсан, хугацаа дууссан, үрэгдүүлсэн, гэмтээсэн, хэдэн ширхэг хэвлүүлснийг бүртгэлийн цахим сүлжээнээс санхүүгийн тайланд татан авч тооцоо бодох боломжгүй байна. | Иргэний бүртгэйин цахим сүлжээг санхүүгийн программтай холбохоор ажиллаж байгаа болно. Тухайн холболтын ажилтай холбогдуулан Мэдээлэл технологийн газар, Иргэний улсын бүртгэлийн газар хамтарч ажиллаж байгаа болно.<br>*Биелэлт 80,0 хувь* |
| 4. | Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг гарахаас өмнө нь хянан баталгаажуулах" гэж заасантай нийцэхгүй байна. | Тайлант хугацаанд нийт 12.299 ширхэг 480.8 сая төгрөгийн гадаад паспортын бэлдэцийг теникийн алдаа гэж зарлага болгосон байна. | АНУ-ын Датакарт компанид үйлдвэрлэгдсэн PB6500 загварын хэвлэх машиныг 2021 онд “Смарткарт” ХХК худалдан авах гэрээний дагуу нийлүүлж суурилуулснаар өнгөт хэвлэлийн модуль 18 сар, лазер модуль 23 сар ашиглагаагүй учир бүрэн хэвлэлт хийж шалгах, хэвийн үйл ажиллагаанд оруулахад багагүй саад бэрхшээл тулгарсантай холбоотой 1-12 сарын хооронд уг техникийн шалтгаанаар хүчингүй болсон байгааг цаашид бууруулахаар ажиллаж байна. |

| | | | |
|---|---|---|---|
| 5. | Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "Төсвийн зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байхад, 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах, 20.2.6-д эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна. | Татварын цахим системийн тодорхойлолтоор 9.568.0 сая төгрөгийн өр төлбөр, авлагын үлдэгдэлтэй байна. | 2023 оны санхүүгийн тайлангийн явцын аудитаар татварын цахим системийн тодорхойлолтоор 9.568.0 сая төгрөгийн өр төлбөртэй байсныг жилийн эцсээр үлдэгдгүй тайлагнаж ажилласан. |
| 6. | Газрын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.7-т "газар дээрх үл хөдлөх хөрөнгө нь тухайн газрын бүрдэл хэсэг байх.", 27 дугаар зүйлийн 27.2-т "Газар эзэмших эрхийн гэрчилгээг зөвхөн Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад олгоно", 27.4-т "Хүчин төгөлдөр эрхийн гэрчилгээгүй аливаа этгээд газар эзэмшихийг хориглоно", 47 дугаар зүйлийн 47.1-д "Газар эзэмших, ашиглах эрх дуусгавар болоход хууль болон гэрээнд өөрөөр заагаагүй бол уг газар дээрх барилга байгууламж, бусад эд хөрөнгө өмчлөгч этгээдийн тэрхүү эд хөрөнгөө тухайн газар дээр ашиглах эрх дуусгавар болно" гэж заасантай нийцэхгүй байна. | Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны А-1/2489 дугаар албан бичгээр Улсын бүртгэлийн ерөнхий газрын биет бус хөрөнгөнд бүртгэлтэй 859 м.кв талбай бүхий нэгж талбараас 402 м.кв талбай бүхий газар эзэмших эрхийг салган Арьсны өвчин судлалын үндэсний төвд шилжүүлэн эзэмшүүлэх зөвшөөрлийг олгосон боловч нягтлан бодох бүртгэлээс хасаагүй, өөрчлөгдсөн газрын гэрчилгээ, кадастрын зургийг гаргуулаагүй байгааг залруулах | Улсын бүртгэлийн ерөнхий газрын balансад байдаг гаражийн газрыг 2 хувааж АӨСҮТ-д шилжүүлэх ажлын бэлтгэл ажлыг хийж дуусгасан. Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ, газрын төлөв байдлын судалгааг "Говь-Эко" ХХК-иар хийж гүйцэтгүүлэн ажлыг гүйцэтгэлийг хүлээн авсан. 2 байгууллагын газрыг шилжүүлэн гэрчилгээг шинэчлэх тухай албан бичгийг 2024 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн 2/6106 тоотоор газрын албанд хүргүүлсэн. |
| | Шилэн дансны хуулийг бүрэн хэрэгжүүлээгүй байна. | Шилэн дансны хуулийн дагуу 2024 оны эхний сарын байдлаар 59 мэдээллээ хугацаанд нь 100 хувь бүрэн байршуулж ажилласан. | |

| | | |
|---|---|---|
| | Аудитын зөрчлийг арилгасан талаарх тайланг хугацаанд нь хүргүүлэх | Үндэсний аудитын газраас 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд орсон аудитаар 23 нэгж "Зөрчилгүй", 1 нэгж "Хязгаарлалттай", 24 нэгжийн төвлөрүүлэн захирагч тайлан "Хязгаарлалттай" дүгнэгдсэн.<br><br>Тус төсвийн захирагч Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар 2,6 сая төгрөгийн төлбөрийн зөрчил бүхий акт 1-ын биелэлт 100,0 хувь, 29,0 сая төгрөгийн төлбөрийн зөрчил бүхий албан шаардлага 3-ын биелэлт 100,0 хувь, зөвлөмжийн биелэлт 96,6 хувь болсныг аудитаас тогтоосон хугацаанаас өмнө үүгээр хүргүүлж байна. |

БОЛОВСРУУЛСАН:
САНХҮҮ, АЖ АХУЙН ХЭЛТСИЙН ДАРГА Б.ӨЭЛҮН-ҮЖИН